



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 01 сарын 15 өдөр

Дугаар A/05

Улаанбаатар хот

Стратеги төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2.Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (П.Алтан-Од) болон харьяа байгууллагын удирдлагууд (Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Үндэсний дата төв УТҮГ, И-Монгол академи УТҮГ, Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба)-д даалгасугай.

3.Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг танилцуулж байхыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга (Ц.Борхүү)-д даалгасугай.

САЙД



Ц.БААТАРХҮҮ

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын
2025 оны 01 дүгээр сарын 03 ний өдрийн
А/05 дугаар тушаалын хавсралт



**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН ЭРХЛЭХ
АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

(2024-2028 он)

Улаанбаатар хот

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ	16
ГУРАВ. АЛСЫН ХАРАА	27
ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО	27
ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	27
ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО	33
ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ.....	34
НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ.....	55
ХАВСРАЛТ. ОЛОН УЛСЫН ИНДЕКС БОЛОН СТРАТЕГИЙН УЯЛДАА ХОЛБОО	56

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
АТГ	Авлигатай тэмцэх газар
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
УОК	Улсын онцгой комисс
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
НОК	Нийслэлийн онцгой комисс
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
КАБЗ	Кибер аюулгүй байдлын зөвлөл
БНҮҮС	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан
СҮЗ	Сансрын үндэсний зөвлөл
РТҮС	Радио телевизийн үндэсний сүлжээ
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОУЦХБ	Олон улсын цахилгаан холбооны байгууллага
ДШХ	Дэлхийн шуудан холбоо
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ТӨК	Төрийн өмчит компани
ТББ	Төрийн бус байгууллага
ОУБ	Олон улсын байгууллага
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны стратеги төлөвлөгөөг Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-т заасныг тус тус үндэслэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”, “Стратеги төлөвлөгөөний загвар”-ыг баримтлан боловсруулсан.

Энэхүү стратеги төлөвлөгөөг тус яамны ерөнхий чиг үүрэг болох харилцаа холбоо, мэдээллийн технологи, шуудан, өргөн нэвтрүүлэг, сансрын технологи, радио давтамж, инновац, кибер аюулгүй байдал, цахим засаглалын талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн төсөл боловсруулах, салбарын хөгжлийн стратегийг тодорхойлох, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлагаар хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах, эрсдэлд суурилсан салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагын хүрээнд боловсруулав.

Түүнчлэн олон улсын байгууллагуудаас гаргадаг улс орны хөгжлийн түвшнийг илэрхийлдэг индексүүд тухайлбал, Дэлхийн инновацийн индекс, цахим засаглалын хөгжлийн индекс, мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн индекс, кибер аюулгүй байдлын индексүүдэд дүн шинжилгээ хийж, тухайн индексэд туссан үзүүлэлт, түүнтэй уялдуулан сайжруулах шаардлагатай арга хэмжээг стратегид тусгасан.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд салбарын хөгжлийн 2024-2028 онд баримтлах стратегийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг гаргахад энэ төлөвлөгөөний зорилго оршино.

1.1. МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Шинэ сэргэлтийн бодлого дунд хугацааны зорилтод хөтөлбөрүүдэд цахим технологид тулгуурлан төрийн үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, хүн амыг харилцаа холбоо, өндөр хурдны интернэт сүлжээнд холбох, цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтцийг бий болгон хөгжүүлэх зорилтуудыг үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Дээрх хөгжлийн бодлого, хөтөлбөрт туссан зорилго, зорилтуудад нийцүүлэн Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас “Цахим Үндэстэн” болох санаачилгын хүрээнд 6 зорилт дэвшүүлэн ажилласан. Үүнд:

- Дижитал дэд бүтцийн бэлэн байдлыг хангах;
- Цахим засаглалыг хөгжүүлэх;
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

- Цахим ур чадварыг дээшлүүлэх;
- Инновац, үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Үндэсний хөгжлийн хурдасгуур.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлагыг хангах “Дижитал дэд бүтцийн бэлэн байдал” зорилтын хүрээнд улсын хэмжээнд дамжуулах сүлжээний багтаамжийг нэмэгдүүлэх, үнэ тарифыг бууруулах чиглэлээр шат дараалсан арга хэмжээ авч ажилласны үр дүнд хүн амын 90 гаруй хувь нь өргөн зурвасын интернэтийн сүлжээнд холбогдож, Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас гаргасан Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн 2024 оны үзүүлэлтээр 170 орноос 87 оноогоор 64 дүгээр байранд орж, 2023 онтой харьцуулахад 1 оноогоор ахисан үзүүлэлттэй байна.

Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологид суурилсан үйлчилгээг хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутагт нэвтрүүлэхэд чиглэсэн томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж, нийт 51,939 км урт шилэн кабелийн сүлжээ байгуулж, бүх аймаг, сумын төв, томоохон суурин газруудад хөдөлгөөнт холбооны 3G, 4G/LTE сүлжээг нэвтрүүлсэн. Үүрэн холбооны нийт идэвхтэй хэрэглэгч 2023 оны жилийн эцсийн байдлаар 4,8 сая хүрч, 100 хүнд ноогдох үзүүлэлт 138.2 болсон нь дэлхийн улс орнуудын дундажтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Үүрэн холбооны 4G/LTE сүлжээ нийт хүн амын 99 хувийг хамарч, үйлчилгээний хэрэглэгчийн тоо 3,4 саяд хүрч, өмнөх оноос 11.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Монгол Улсын хэмжээнд 1639 баг байгаагаас 1448 багийн 178194 өрх үүрэн холбооны сүлжээнд холбогдсон бөгөөд цаашид багуудыг үүрэн холбооны сүлжээнд холбох ажил үргэлжилж байна.

Интернэтийн гадаад урсгалын нийт багтаамж жил бүр өсөж байгаа бөгөөд 2023 онд 590,5 Гбит/сек-д хүрч, 2022 онтой харьцуулахад 3.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Монгол Улсаар дамжиж байгаа олон улсын интернэтийн транзит урсгалын хэмжээ 2023 оны жилийн эцсийн байдлаар 1,800 Гбит/сек-д хүрчээ.

Суурин интернэт хэрэглэгчийн тоо 2023 оны байдлаар 498,889-д хүрсэн бөгөөд улсын хэмжээнд нийт өрхийн 48 орчим хувь нь суурин интернэтэд холбогдсон байна. Суурин интернэт хэрэглэгчийг байршлаар нь авч үзвэл 76.03 хувь нь Улаанбаатар хотод, 23.97 хувь нь орон нутгийн хэрэглэгч эзэлж байна. Түүнчлэн суурин телефон үйлчилгээний 524,075 хэрэглэгч байгаагаас 80.2 хувь нь АйПиТВ хосолсон үйлчилгээний хэрэглэгч байгаа бөгөөд нийт суурин телефон хэрэглэгчийн 90.6 хувь нь өрхийн, 9.3 хувь нь байгууллагын хэрэглэгч байна.

Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн технологийг (5G) нэвтрүүлэхэд баримтлах чиглэлийг 2020 онд баталж, 2021-2022 онд 5G технологийг нэвтрүүлэх техникийн туршилтыг амжилттай зохион байгуулсан. Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд 2023 онд оруулсан өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсад дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5G технологид ашиглах радио давтамж, ФМ өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд ашиглах радио давтамжийн хуваарилалтыг шинэчлэн баталж, ФМ өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих боломжийг нээсэн. Хөдөлгөөнт холбооны 5G технологид суурилсан үйлчилгээг нэвтрүүлснээр өндөр хурдны интернэт, машин хоорондын холбоо, юмсын интернэт үйлчилгээ хөгжиж, харилцаа холбоо, мэдээллийн технологи, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, хөдөө аж ахуй, зам тээвэр, уул уурхай, худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл, автоматжуулалтын салбарт томоохон шинэчлэлийг бий болгох юм.

Сансар судлалын техник технологийг хөгжүүлэх, үндэсний хиймэл дагуул хөөргөх, сансрын технологийн мэдээллийг боловсруулж, ашиглах үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр "Монгол Улсад сансар судлалыг хөгжүүлэхэд баримтлах чиглэл (2023-2033)"-ийг 2022 онд баталсан. Мөн Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас манай улсад хуваарилсан геостационар орбитын 113.6E байрлалыг ашиглах "CHINGGIS" хиймэл дагуулын төлөвлөлтийг дээрх байгууллагад бүртгүүлж баталгаажуулсан.

Монгол Улсын нийт өрхийн 97.3 хувь нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг радио, телевизийн газрын сүлжээ болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжуулан хүлээн авахын зэрэгцээ гадаадын 199 сувгийг олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжуулан хүлээн авч байна.

Телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгч 2023 онд 761,800 болж, өмнөх оноос 0.23 хувиар өссөн бөгөөд технологийн төрлөөр авч үзвэл нийт хэрэглэгчийн 56.33 хувь нь АйПиТв-ээр, 34.47 хувь нь хиймэл дагуулаар, 9.2 хувь нь кабелийн телевизээр үйлчилгээг хүлээн авч байна. 2022 оноос нийт хэрэглэгчийн сонгож буй технологид АйПиТв-ийн эзлэх хувь давамгайлж байгаа боловч хөдөө, орон нутагт хиймэл дагуулаар үйлчилгээ авах сонголт хэвээр байна.

Монгол Улсын шуудангийн салбарын хууль эрх зүй, зохицуулалтын таатай орчин бүрдэж, зах зээлийн өрсөлдөөн нэвтэрсэн ба шуудангийн үйлчилгээний хүртээмж, чанар жилээс жилд сайжирч байна. Дэлхийн шуудан холбооноос жил бүр шинэчлэн гаргадаг Шуудангийн хөгжлийн индексээр уг холбооны гишүүн орнуудыг 10 түвшинд эрэмбэлдэг бөгөөд 2023 онд Монгол Улс 46,7 оноогоор 6 дугаар түвшинд жагсаж, 2022 онтой харьцуулахад 6 оноогоор буюу 1 түвшингээр ахисан үзүүлэлттэй байна.

Нийгэм, эдийн засгийн бүх салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологи, инновацыг нэвтрүүлж, бүтээмж, өрсөлдөх чадвар, үр ашгийг нэмэгдүүлэх замаар хүнд сурталгүй, ил тод нээлттэй байдлыг хангах **"Цахим засаглалыг хөгжүүлэх" зорилтын хүрээнд** Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор 26, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын тушаалаар 33 актыг тус тус батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийтийн мэдээллийн дэд бүтцийн бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд Үндэсний дата төвийн сервер, тоног төхөөрөмжийг олон улсын чиг хандлагад нийцүүлэн өргөтгөн сайжруулж, төр, хувийн хэвшлийн хамтарсан "mcloud.gov.mn" үүлэн дэд бүтцийг нэвтрүүлэн, сүлжээний төхөөрөмжүүдийг виртуалчилан удирдах боломжийг бүрдүүлсэн.

Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-д төрийн 142, хувийн хэвшлийн 390 байгууллагын 816 үйлчилгээг холбож, 3,4 тэрбум үйлчилгээг амжилттай дуудсан байна. Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ийн үйл ажиллагаанд нэмэлт хөгжүүлэлт хийж, 2023 онд "e-mongolia 3.0" 2024 онд "e-mongolia 4.0" хувилбарыг тус тус хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд тус систем нь e-Mongolia (иргэн), e-business.mn (хуулийн этгээд), lavlagaa.e-mongolia.mn (үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд), operator.e-mongolia.mn (ХУРДАН төрийн үйлчилгээ), kiosk.e-mongolia.mn (ХУРДАН төрийн үйлчилгээ), мобайл аппликейшн гэсэн 6 суваг ашиглан иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлж байна. Тус системд 1,9 сая хэрэглэгч бүртгүүлж, 87 байгууллагын 1263 үйлчилгээг холбон, 65 сая удаагийн үйлчилгээг амжилттай дамжуулан 1,3 их наяд төгрөгийн шууд бус зардлыг хэмнэсэн.

Тоон гарын үсгийг түгээх ажлыг эрчимжүүлж, иргэнийг таньж баталгаажуулах зорилготой танилт, нэвтрэлтийн систем (ДАН)-д тоон гарын үсгийн модулийг холбож, иргэн, хуулийн этгээдийг тоон гарын үсгээр дамжуулан таних боломжийг бүрдүүлсэн ба 2025 оны 01 дүгээр сарын байдлаар уг системд нийт 2,172,887 хэрэглэгч бүртгүүлж, төрийн 85 байгууллагын 160, хувийн хэвшлийн 244 байгууллагын 279 системийг холбосон. Харин тоон гарын үсгийн гэрчилгээг төрийн 1, хувийн хэвшлийн 5 байгууллагаар дамжуулан нийт 1,4 сая иргэн, хуулийн этгээдэд олгосон.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар хүн, хуулийн этгээдэд хамаарах хязгаарлалттай мэдээллийг хуульд заасан үндэслэл, журам, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлөөр танилцах, ашиглах, эсхүл гуравдагч этгээдэд дамжуулна гэж заасны дагуу мэдэгдэл хүргэх системийг хөгжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, үндэсний цахим шуудан, хувийн цахим шуудангаар дамжуулан нийт 30,7 сая мэдэгдлийг иргэнд хүргэсэн.

Цахим ардчиллыг хөгжүүлж, төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих зэргээр цахимаар оролцох тэгш боломжийг бүрдүүлэх зорилготой "petition.parliament.mn" систем, төрийн үйл ажиллагааг хэлэлцэхэд ашиглагдах "e-tanhim.gov.mn"-ийн 2.0 хувилбар болон "e-cabinet"-ийн мобайл хувилбарыг тус тус хөгжүүлэн хэрэглээнд нэвтрүүлсэн.

Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлж, албан бичиг солилцооны дундын систем "DocX"-ийг хөгжүүлэн, 5000 гаруй байгууллагын ашигладаг 17 албан бичиг боловсруулалтын системтэй холбож, 2413 байгууллага холбогдон 136,888 бичиг 178,328 хавсралтын хамтаар илгээн, 165,628 бичиг хүлээн авсан байна. Түүнчлэн хөдөө, орон нутаг, алслагдсан сум суурин газрын иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдыг нэгдсэн мэдээллээр хангах зорилготой "huduu.mn"-ийг хөгжүүлж, 46,295 мэдээллийг тухай бүр шинэчлэн, тасралтгүй ажиллааг хангаж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх" жил болгон зарлаж, Засгийн газрын 49 дүгээр тогтоол, Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгаврын дагуу "Шил" ажиллагааг хэрэгжүүлж, нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" системийг ашиглалтад нэвтрүүлсэн. Уг системд яам, агентлаг, аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа мэдээлэл хариуцагч байгууллагын 39 төрлийн 970 355 мэдээллийг байршуулж, 15,758,833 удаагийн хандалтыг авсан байна. Энэ нь иргэдэд төрийн үйл ажиллагааг хянах боломжийг олгосон бөгөөд шилэн индексийн үнэлгээгээр байнга ил тод, нээлттэй байхаар хуульчилсан 5 чиглэлийн 68 төрлийн мэдээллийн ил тод байдлын үзүүлэлт 2023 онд 38%-тай байсан бол 2024 онд 91%-тай болж дээшиллээ. 2025 оны 1 дүгээр сарын байдлаар хандах эрхийг мэдээлэл хариуцагч 1637 байгууллагын 1863 албан хаагчдад үүсгэж, 1200 гаруй албан хаагчдыг сургалтад хамруулсан.

Хөдөө орон нутаг, алслагдсан сум, суурин газар болон хилийн чанадад байгаа ард иргэд, байгууллагуудад төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг 2023 онд байгуулж, түүний салбар, харьяа төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэгийг нийслэлд 101, орон нутагт 295, хилийн чанад дахь 31 улсын 47 байршилд, хилийн 1 боомтод тус тус нээж, 43 байгууллагын 471 үйлчилгээг нийт 1 сая гаруй хүн, хуулийн этгээдэд үзүүлээд байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, Төрийн их өгөгдөл бүрдүүлэх, бодлого, шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд ил тод, хүртээмжтэй болгох бодлогын хүрээнд төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал

(<http://opendata.gov.mn/>) 2.0 хувилбарыг хөгжүүлж нэвтрүүлсэн. Нээлттэй өгөгдлийн шинэ системийг ашиглалтад нэвтрүүлсэнтэй холбогдуулан хуучин серверт байгаа өгөгдлийн бүрдэл, файлын санг шинэ системд шилжүүлсэн. Өнөөдрийн байдлаар тус системд 53 байгууллагын 2633 өгөгдлийг машинд уншигдах форматаар байршуулсан.

Цахим орчинд үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлж, орчин үеийн техник технологийг нэвтрүүлэн, төр, хувийн хэвшил, иргэний мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх **“Мэдээллийн аюулгүй байдлыг хангах” зорилтын хүрээнд** Кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бэхжүүлж, онц чухал мэдээллийн дэд бүтцийг хамгаалах, кибер аюулгүй байдлыг хангах боловсон хүчнийг чадавхжуулах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, кибер халдлага, зөрчилтэй тэмцэх бүтцийг бүрдүүлэх зорилго бүхий “Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги”-ийг Засгийн газрын 2022 оны 493 дугаар тогтоолоор баталсан. Тус стратегийг 5 үндсэн зорилтын хүрээнд 2027 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засагт хохирол учруулж болохуйц мэдээллийн систем, мэдээллийн сүлжээ бүхий онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй төрийн 134 байгууллага, хувийн хэвшлийн 82 байгууллагыг тодорхойлж, Засгийн газрын 2022 оны 207 дугаар тогтоолоор батлуулж, кибер аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэхийг үүрэгжүүлсэн. Эдгээр байгууллагууд нь кибер аюулгүй байдлыг өндөр түвшинд хангаж, хариуцсан мэдээллийн системийн хэвийн тасралтгүй ажиллагааг хангаснаар төрийн тогтвортой үйл ажиллагаа, иргэдийн амар тайван ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Засгийн газрын 2023 оны 42 дугаар тогтоолоор Кибер аюулгүй байдлын зөвлөл, түүний Ажлын албыг байгуулж, кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээлэл солилцох ажлыг уялдуулан зохицуулж байна. Мөн Засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолоор кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журмыг баталж, хуулийн этгээдийн мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний кибер аюулгүй байдлыг хангах, кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхтэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгосон.

Хүний хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь дэлхий дахинаа тулгамдаж байгаа чухал асуудлын нэг бөгөөд Монгол Улс нь 2021 онд Хүний хувийн мэдээллийг хамгаалах хуультай болж, 2022 оноос эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Бүх салбарт хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангах, хүн өөрийн мэдээллийн эзэн байх эрхийг хамгаалсан зохицуулалтыг тодорхой болгосон. Хуулийн хүрээнд хүний биометрик мэдээлэл буюу дахин давтагдашгүй биеийн өгөгдөл болох 637,024 иргэний гарын хурууны хээ 2,464 байгууллагад цугларсан байсныг шалгаж тогтоон, устгах ажлыг зохион байгуулсан. Мөн хүний хувийн мэдээлэлд гуравдагч этгээд хандсан тухай мэдэгдэл хүргэх системийг ашиглалтад оруулж, 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 14,457, 136 удаа иргэдэд мэдэгдэл хүргээд байна.

Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “e-Mongolia”-ийн мэдэгдэл хүргэх сувгаар нийт 30,726,116 мэдэгдлийг хүн, хуулийн этгээдэд хүргүүлсэн ба үүнээс үндэсний цахим шуудангаар 21,375,666, хувийн цахим шуудангийн хаягаар 442,286, “push notification”-ээр 8,908,164 мэдэгдэл илгээгдсэн байна.

Сүүлийн жилүүдэд зорилтот халдлага, зөрчил, кибер гэмт хэргийн тоо улам бүр өссөөр байгаа бөгөөд 2023 оны байдлаар Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний хамгаалагдсан интернэт сүлжээнд холбогдсон 54 байгууллагад 5,414,410 ноцтой, 48,843,447 өндөр түвшний кибер халдлага илэрсэн бол Үндэсний дата төв УТҮГ-ын

хамгаалалтын системд 32.5 тэрбум удаагийн хандалт бүртгэгдсэний 9.9 тэрбум нь дүрмийн бус, халдлагын шинжтэй гэж бүртгэгдсэн.

Кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, мэдээллийн системийг нөхөн сэргээх үйл ажиллагааг зохицуулж, мэргэжлийн удирдлагаар хангах “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төв” УТҮГ-ыг Засгийн газрын 2023 оны 319 дүгээр тогтоолоор байгуулж, олон улсын ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай мэдээлэл, туршлага харилцан солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх бодлого барин ажиллаж байна.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн ололт, амжилтад тулгуурлан нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт инновац хийх чадвартай бүтээлч иргэдийг бий болгох “Цахим ур чадварыг дээшлүүлэх” зорилтын хүрээнд Монгол Улсад бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээ, үзэл баримтлал, дизайныг тодорхойлох, иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах зорилгоор тус яам, Боловсрол шинжлэх ухааны яам, Боловсролын үндэсний хүрээлэн, И-Монгол академи, их дээд сургуулийн багш нар болон олон улсын байгууллагын төлөөллүүдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдан ажилласан бөгөөд тус ажлын хэсгийн хүрээнд асуудал шийдвэрлэх, ёс зүй, мэдээлэл өгөгдөл техниктэй ажиллах, хамтран ажиллах, эрүүл мэнд, аюулгүй байдал, идэвхтэй оролцоо, системийн болон загварчлах сэтгэлгээ, харилцаа холбоо гэсэн чадамжид хамаарах ур чадваруудыг тодорхойлон эдгээр үзүүлэлтийг олон улсын цахим ур чадварын бүтцийн хүрээтэй харьцуулан судалсан. Мөн тус ажлын хэсгийн хүрээнд Нэгдсэн үндэсний байгууллагын Хурдасгуур лаборатори, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн хамтран “Иргэдийн цахим ур чадварын хэрэгцээ тодорхойлох судалгаа”-г хийсэн. Тус судалгааг нийгмийн хэд хэдэн бүлгүүдээс түүвэрлэн авахад дээрх чадамжийн хүрээний онцлог бүрээр цахим ур чадварыг дээшлүүлэх шаардлага байгааг харуулсан.

Дэлхийн олон улс орнууд иргэдийн албан болон албан бус боловсролын зайлшгүй байх ур чадварт цахим ур чадварыг нэн тэргүүнд тавьж, цахим ур чадварын бүтцийн хүрээг тодорхойлсон бөгөөд 2022 оны байдлаар 11 улс бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээг боловсруулан хэрэгжүүлж байгаа бол 36 улс олон улсын байгууллагаас гаргасан бүтцийн хүрээг холбогдох сургалтдаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Тус яамнаас холбогдох төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагатай хамтран олон улсад нийтлэг мөрдөж байгаа Иргэдэд зориулсан цахим ур чадварын хүрээ (DigComp), Дэлхийн цахим ур чадварын хүрээ (DLGF), Тоон ур чадварыг бодит үр дүнд хүргэх ур чадварын хүрээ (DiSTO), Тоон бичиг үсгийн гэрчилгээ – Майкрософт, Дижитал бичиг үсэг тайлагдалтын хөтөлбөр - IC3, Сингапурын дижитал чадамжийн нэгдсэн хүрээ зэрэг 12 улсын цахим ур чадварын бүтцийн хүрээг судалгааны үр дүнтэй харьцуулан бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээний төслийг 6 тэргүүлэх чиглэл, 18 чадамж, чадамж бүрд хамаарах мэдлэг, ур чадварыг багцлан боловсруулж, “Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээ” -г Засгийн газрын 2024 оны 141 дүгээр тогтоолоор батлуулсан.

Цахим ур чадварын бүтцийн хүрээ нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн талаар иргэдэд нийтлэг ойлголтыг бий болгох бөгөөд сургалтын төлөвлөгөө, үнэлгээний хэрэгсэл болон хөтөлбөр боловсруулахад чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн иргэдийн цахим ур чадварын түвшнийг олон улсын үнэлгээнд нийцсэн байдлаар үнэлэх, үнэлгээнд үндэслэн шаардлагатай ур чадваруудыг дээшлүүлэх сургалт хөгжүүлэлтийн арга хэмжээ авах, иргэн өөрийгөө хөгжүүлэх боломж бүрдэнэ. Үүний үр дүнд иргэдийн цахим ур чадвар сайжирч цахим үйлчилгээг түргэн шуурхай авах, ахуй амьдралдаа дэвшилтэт

технологийг ашиглах, улмаар нийгэм эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой юм.

Мэдээллийн технологи, их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилсан дэвшилтэт технологи, гарааны бизнесийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, олон улсад өрсөлдөх чадамжийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалт татах, мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх **“Инновац, үйлдвэрлэлийг хөгжүүлэх” зорилтын хүрээнд** инновацыг хөгжүүлэхэд баримтлах бодлогын чиглэлийг боловсруулж, холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгон, инновацыг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих, программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг төрөөс татварын болон татварын бус бодлогоор дэмжин мэдээллийн технологийн гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар баталсан. Улмаар Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх Үндэсний зөвлөлийг Засгийн газрын 2024 оны 97 дугаар тушаалаар батлуулан холбогдох журам, стратеги, дэвшилтэт технологийн жагсаалт болон сэндбоксын журам батлуулах үйл ажиллагааг шат дараатай хэрэгжүүлж байна.

Олон улс болон үндэсний хэмжээнд инновац, мэдээллийн технологийн үйлдвэрлэл, гарааны бизнесийг дэмжих зорилгоор Америк, Их Британи, Энэтхэг, Солонгос, Казакстан, Узбекистан, Турк улсууд болон Нэгдсэн үндэстний байгууллага, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага зэрэг олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байна.

Түүнчлэн шинэ технологийн шийдлийг Монгол Улсад нэвтрүүлэх, хурдацтай хөгжиж буй цахим эдийн засгийг дэмжих зорилгоор дроны туршилтын бүс байгуулах, мэдээллийн технологийн төрөлжсөн төвүүдийг бүсүүдэд байгуулах, блокчейн технологийг салбар бүрд нэвтрүүлэх, хиймэл оюун ухааны хэрэглээг нэмэгдүүлэх, их өгөгдлийн нэгдсэн сан бүрдүүлэх зэрэг ажлуудыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна.

Нийгэм, эдийг засгийн бүхий л салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж, өрсөлдөх чадвар, бүтээмж, үр өгөөжийг дээшлүүлэх **“Үндэсний хөгжлийг хурдасгах” зорилтын хүрээнд** салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиглэлээр 16 яам, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороо, Биеийн тамир, спортын улсын хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас баталсан 2020-2026 онд буюу дунджаар 3-6 жилийн хугацаанд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөнд нийт 445 зорилт, 1827 арга хэмжээ туссанаас харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр тусгайлан заасан 84 зорилт, 319 арга хэмжээ, бусад зорилт үйл ажиллагаатай уялдуулан заасан 65 зорилт, 93 арга хэмжээ байна. Эдгээр 19 байгууллагын стратегийн төлөвлөлтөд харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр туссан арга хэмжээ дунджаар 22.6%-тай байна. Эдгээр цахим шилжилтийн бодлогын хэрэгжилтэд салбар хоорондын уялдааг хангах, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, цахим засаглал, цахим шилжилтийг нэгдсэн төлөвлөлттэй хэрэгжүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор тус яам нь дараах ажлыг холбогдох яамд бусад мэдээлэл хариуцагч байгууллагуудтай хамтран хэрэгжүүллээ. Үүнд:

Хууль зүй, дотоод хэргийн салбарын цахим шилжилтийн хүрээнд:

Шүүх шинжилгээний тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэгт заасан "Цахим технологийн шинжилгээ хийх журам"-ыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны "Журам батлах тухай" А/315, А/91 дүгээр хамтарсан тушаалаар баталсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын цахим шилжилтийн хүрээнд:

Монгол Улсын Их Хурлын 2022 оны "Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 71 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлсэн ба иргэд 189,599 удаа хандсан байна.

Зам, тээврийн салбарын цахим шилжилтийн хүрээнд:

Нийслэл Улаанбаатар хотын гэрлэн дохиотой 161 автозамын уулзвар, 8 шалган бүртгэх товчоо, 5 техникийн хяналтын үзлэгийн төв нийт 174 байршилд 455 радио давтамж тодорхойлох /RFID tag/ уншигч, 1,036 антен, бусад төхөөрөмжийг суурилуулж, "Авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ", "Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID tag)" болон авто тээврийн хэрэгслийн эзэмшигч шилжүүлэх үйлчилгээг тус тус төрийн үйлчилгээний нэгдсэн систем "E-Mongolia"-д нэвтрүүлсэн. Монгол Улсын хэмжээнд 1,177,394 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн ба үүний 58.2% буюу 685,643 нь нийслэл Улаанбаатар хотод бүртгэлтэй байгаа бөгөөд 2023 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн 2024 оны 12 сарын 02-ны өдрийн байдлаар 442,195 тээврийн хэрэгсэлд "RFID tag" суурилуулаад байна.

Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн хүрээнд:

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасан "Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журам"-ыг Засгийн газрын 2024 оны "Журам батлах тухай" 100 дугаар тогтоолоор, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсэг заасан "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлагыг тогтоох, үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журам"-ыг Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны А/138, А/37 дугаар хамтарсан тушаалаар тус тус батлуулсан. Мөн Монгол Улсын "Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын хөндлөнгийн үнэлгээ"-г олон улсын байгууллагатай хамтран хийж, "Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд" үндэсний зөвлөлдөх уулзалт, сургалтыг улс орон даяар зохион байгуулан, эрүүл мэндийн салбарын төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, 400 гаруй эрүүл мэндийн байгууллагууд хооронд мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн. Эмийн чанар, аюулгүй байдлыг хангах хүрээнд "Эмийн бүртгэл, мэдээллийн LICEMED систем"-ийн мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэн, "Эмийн жор"-ын хэрэглээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэн, 70 орчим төрлийн 120 гаруй эмийн хэрэглэх зааврыг AR технологиор баяжууллаа.

Боловсрол, шинжлэх ухааны салбарын цахим шилжилтийн хүрээнд:

"Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэхэд тавих ерөнхий шаардлага" MNS 6984:2022 стандарт, монгол хэл, бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Монгол бичгийн юникод стандартын техникийн дүрмийн орчуулга", "Монгол бичгийн юникод стандартын үсгийн хэлбэр хувирлын сонголтын дүрэм"-ийг боловсруулж, "Монгол хэлний компьютерын орчны тогтолцоо, тооцоолох хэрэгслийн гарын товчлуур дээрх монгол бичгийн үсэг, тэмдэгтийн байршил" MNS 7004:2023 стандартыг тус тус батлуулсан. Мөн 2023 оны хичээлийн жилээс эхлэн Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн мэдээллийн технологийн гүнзгийрүүлсэн сургалттай 2 анги нээсэн.

Соёлын салбарын цахим шилжилтийн хүрээнд:

“Цахим соёл” цогц арга хэмжээг хэрэгжүүлж, “Урын сангийн систем”, “GLAM систем”, “Номын сангийн мэдээллийн нэгдсэн систем”, “Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем”-ийг нэвтрүүлсэн. “Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем”-ийг анх Говь-сүмбэр, Дархан-Уул, Архангай аймагт нэвтрүүлж улмаар 2024 оны жилийн эцсийн байдлаар 21 аймаг нэвтрүүлсэн. /21 аймаг, нийслэлийн хэмжээнд 9,590 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, 7,100 түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл (дэс), 14,123 түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, 1,554 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар, 15,274 түүх, соёлын үл хөдлөх дурсгал, 5 баримтат өв бүргэгдээд байна.

Санхүү, эдийн засаг, хөгжлийн салбарын цахим шилжилтийн хүрээнд:

Зөвшөөрлийн тухай хуульд 252 тусгай зөвшөөрөл, 121 энгийн зөвшөөрөл нийт 373 зөвшөөрөл олгохоор батлагдсан. Үүнээс зөвшөөрөл олгож буй байгууллагын цахим системээр 185, Санхүүгийн мэдээллийн технологийн төвийн цахим системээр 53, И-Монгол академийн нэгдсэн системээр 44, уламжлалт цаасан хэлбэрээр 73 зөвшөөрлийн үйл ажиллагаа явагдаж байна. Мөн 18 тусгай зөвшөөрлийг уг хуулийн хүрээнд цахим хэлбэрт шилжүүлэх боломжгүйг тогтоогоод байна.

Гадаад харилцааны салбарын цахим шилжилтийн хүрээнд:

Төрийн үйлчилгээний нэгдсэн системд гадаадын иргэнийг таньж, баталгаажуулах нэвтрэлтийн системийг нэвтрүүлсэн.

Барилга, хот байгуулалтын салбарын цахим шилжилтийн хүрээнд:

Газрын кадастрын нэгдсэн системд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нарын хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагааг эрхлэн явуулж, газрын бүртгэлийг баталгаажуулах, цахимжуулах ажлыг хэрэгжүүлснээр Улсын хэмжээнд нийт өмчлөх эрх үүссэн 577,180 газар, эзэмших эрх үүссэн 457,534 газар, ашиглах эрх үүссэн 5,963 газар буюу нийт 979,697 газар тус тус бүртгэгдэж баталгаажсан байна. Газрын биржийн цахим систем ашиглан дуудлага худалдааг цахимаар зохион байгуулснаар дуудлага худалдааны орлогын хэмжээ 6.1 дахин нэмэгдсэн байна.

Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн салбар, харьяа байгууллагын хүрээнд программ хангамжийн судалгаа авч, нэгтгэхэд яам, түүний эрхлэх асуудлын хүрээний төрийн захиргааны байгууллагад 187, нутгийн захиргааны байгууллагад 53 нийт 240 төрлийн программ хангамж ашиглагдаж, үүнээс улсын төсвийн хөрөнгөөр захиалсан болон төрийн байгууллагын мэдээллийн технологийн нэгж, албан хаагчийн хөгжүүлсэн 104 буюу 43.3%, хувийн хэвшил хөгжүүлж төрийн байгууллагатай гэрээ байгуулан ашиглуулдаг 116 буюу 48.4%, хаанаас санхүүжүүлсэн болон хэн хөгжүүлсэн нь тодорхойгүй 20 буюу 8.3% байна. Программ хангамжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөгжүүлэлт хийлгэх боломжийг нээх, төрийн программ хангамжийн худалдан авах үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах, үргүй зардлыг бууруулах зорилгоор Засгийн газрын 2023 оны “Мэдээллийн технологийн программ хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 311 дүгээр тогтоолын дагуу “Үндэсний программ хангамжийн их дэлгүүр” /Mindgolia/ системийг нийтийн мэдээллийн дэд бүтцийн дэмжих систем болгож, төсвөөс хөгжүүлэлт хийхгүй байх программ хангамжийн 32 чиглэлийг баталсан. Дээрх системийг 2022 оны 12 дугаар сард хэрэглээнд нэвтрүүлснээс хойш уг системд 247 аж ахуйн нэгж, байгууллагын 484 бүтээгдэхүүн, үйлчилгээг байршуулаад байна.

1.2. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлж, мэдлэг оюунд тулгуурласан Цахим Үндэстнийг хөгжүүлэхэд дараах хүндрэл бэрхшээл тулгарч байна:

Харилцаа холбооны чиглэлээр:

Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд "Монгол Улсад хөдөлгөөнт холбооны 5G сүлжээг нэвтрүүлэх", "Цахим Үндэстэн 2022-2027" дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн 1.1.4-д "Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын хурдасгуур болсон хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн технологийг нийгэм эдийн засгийн бүх салбарт нэвтрүүлэхэд салбар хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлнэ" гэж заасан байдаг. Түүнчлэн Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн технологийг (5G) нэвтрүүлэхэд баримтлах чиглэлийг 2020 онд баталж, 2021-2022 онд 5G технологийг нэвтрүүлэх техникийн туршилтыг амжилттай зохион байгуулсан. Дээрх бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний дагуу 5G сүлжээг нэвтрүүлэхэд технологийн онцлогоос хамаарч антен хоорондын зай ойртох тул илүү олон бааз станц байгуулах шаардлага үүсэж байгаагийн зэрэгцээ цаашид хот суурин газрын байшин, барилга дээр антен суурилуулах, орон нутагт шилэн кабелийн сүлжээг өргөтгөх зэрэгт газар ашиглах хэрэгцээ улам бүр нэмэгдэнэ. Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор зам, шугам сүлжээний газрын суурь үнийг тухайлан тогтоогүйгээс арилжааны шинж чанар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалттай газарт хамааруулсан байдаг. Үүнээс улбаалж газар эзэмших суурь үнэ нь шилэн кабель, цамхаг суурилуулах хөрөнгө оруулалтын хэмжээнээс даруй 2 дахин өндөр өртөгтэй болсон. Иймд мэдээлэл, харилцаа холбооны шугам сүлжээний зориулалттай газрыг газрын төлбөрөөс хөнгөлөх зохицуулалтад хамруулах, мөн харилцаа холбооны шугам сүлжээний зориулалтын газрыг бусад дэд бүтцийн шугам сүлжээний нэгэн адил хялбаршуулсан байдлаар олгодог болох нөхцөлийг бий болгох нь цахим шилжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх өндөр ач холбогдолтой юм.

Түүнчлэн цахим шилжилтийг эрчимжүүлэх, салбар хоорондын уялдаа холбоог хангах үүднээс газар зохион байгуулалтын ерөнхий болон аймаг, нийслэл, сумын жилийн төлөвлөгөөнд харилцаа холбооны сүлжээ байгуулах газрыг тусгуулах, хот тэлэлт, томоохон бүтээн байгуулалт, чөлөөт бүс, болон кластер төвүүдийн төлөвлөлтөд харилцаа холбооны сүлжээний дэд бүтцийг бусад инженерийн шугам сүлжээ, дэд бүтэцтэй хамт цогцоор нь төлөвлөх, хот, суурин газарт байгуулсан сүлжээг хамгаалах асуудлыг шийдэж, холбогдох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Сансрын технологи, радио давтамжийн чиглэлээр:

Өргөн уудам газар нутагтай манай орны хувьд хүн амьдрах боломжтой газар нутгаас 26.8 хувийг үүрэн холбооны сүлжээгээр холбосон бөгөөд газар нутгийн үлдсэн хувийг интернэт, харилцаа холбооны сүлжээнд холбоход зардал өндөр байна. Хүн амьдран суух боломжтой бүс нутаг буюу Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 65 хүртэлх хувийг үүрэн холбооны сүлжээнд хамруулна гэвэл 12 их наяд төгрөг зөвхөн дэд бүтцийн зардалд гарах тооцоо байдаг. Мөн өргөн уудам нутагт үүрэн холбооны антен, цамхаг байгуулах, өрх бүрд шилэн кабелийн сүлжээ хүргэх боломжгүй учир иргэн бүрд интернэт, харилцаа холбооны үйлчилгээ хүргэх дэвшилтэт арга зам бол үндэсний хиймэл дагуулыг хөөргөх явдал юм. Монгол Улс өөрийн эзэмшлийн харилцаа холбооны үндэсний хиймэл

дагуултай болсноор эдийн засгийн тогтвортой байдал, үндэсний аюулгүй байдлаа хамгаалах давуу тал бий болохын зэрэгцээ шилэн кабелийн нөөц гарцтай болох боломжтой байна.

Техник, технологийн шинэчлэлтэй холбогдуулан 4 жил тутамд нэмэлт, өөрчлөлт ордог Дэлхийн Радио холбооны дүрмийг үндэслэн Үндэсний радио давтамжийн төлөвлөлт, хуваарилалтын 20-с доошгүй хувийг шинэчлэх шаардлага үүсдэг. Түүнчлэн хил залгаа хөрш орнуудтай хил орчмын радио давтамжийн зохицуулалтыг сайжруулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Радио, өргөн нэвтрүүлгийн чиглэлээр:

Телевизийн өргөн нэвтрүүлгийг 2015 онд тоон технологид бүрэн шилжүүлж, улс орон даяар урт, дунд, богино долгионы их чадлын 10 станцаар үндэсний олон нийтийн радиогийн 1, 2 дугаар хөтөлбөрийг дамжуулж байгаа бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 50 гаруй хувь нь дунд сонсголын, хүн амын 40 гаруй хувь нь найдвартай сонсголын бүсэд хамрагдаж байна. Радио, телевизийн газрын сүлжээ, дэд бүтцийг өргөтгөх, сүлжээний багтаамжийг нэмэгдүүлэх, радиогийн дамжуулах сүлжээг тоон технологид шилжүүлэх, дэд бүтцийн бэлэн байдлыг хангах, өргөн нэвтрүүлгийн салбарт үндэсний ашиг сонирхол, үндэсний дархлааг хамгаалах, эзэмшлийн ил тод байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлж, салбарын хөгжлийг дэмжин хөгжүүлэхэд онцгой анхаарч төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох зайлшгүй шаардлагатай байна. Монгол Улсын хувьд өргөн уудам газар нутагтай, хүн амын нягтаршил сийрэг зэрэг онцлог байдалдаа тохируулж орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан хэрэглэгчдийн хүсэлт, шаардлагад нийцсэн телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн сүлжээг бий болгох шаардлагатай байна.

Шуудан, цахим худалдааны чиглэлээр:

Монгол Улсын шуудангийн салбарын хууль эрх зүй, зохицуулалтын таатай орчин бүрдэж, зах зээлийн өрсөлдөөн нэвтэрсэн ба шуудангийн үйлчилгээний хүртээмж чанар жилээс жилд сайжирч байгаа боловч бүсчлэлээс хамааран харилцан адилгүй, эрс ялгаатай байна. Аймаг, орон нутаг, алслагдсан сум сууринд оршин сууж буй иргэдийн шуудангийн үйлчилгээний хүртээмж, шуудангийн үйлчилгээний хурд хангалтгүй байна.

Улсын хэмжээнд 2021 оны байдлаар 95 аж ахуйн нэгж, байгууллага шуудангийн ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хэдий ч, шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчээс бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж, байгууллагууд орон нутагт шуудангийн үйл ажиллагаа явуулахгүй байна. Түүнчлэн хүн ам нягт суурьшсан Улаанбаатар хотын жижиг зах зээлд хэт олон өрсөлдөгч үйл ажиллагаа явуулж байгаагаас зөвхөн шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигч нь алслагдсан бүс нутагт, зардал хамгийн их хэсэгт ажиллаж, алдагдал хүлээж байгаа нь үндсэн сүлжээ эзэмшигчийн найдвартай, тогтвортой байдалд эрсдэл учирч байна. Иймд Монгол Улсын хаягийн эмх замбараагүй, ойлгомжгүй байдалд дүн шинжилгээ хийж, шуудангийн болон захиалгат хүргэлтийн үйлчилгээг хурдан, шуурхай хүргэх, цахим худалдааг хөгжүүлэх шаардлага нэн тэргүүний тулгамдсан асуудлуудын нэг болоод байна.

Шуудангийн зах зээл нь өмнөх жилүүдэд бичиг, цаас, захиа, сонин хэвлэл зэрэг цаасан суурьтай уламжлалт шуудангийн үйлчилгээ нийт солилцооны 90 хувийг эзэлдэг байсан бол сүүлийн үед дэлхий дахинаа цахим шилжилт эрчимтэй явагдаж байгаагаас улбаалан энэ тоо огцом буурсан. Хэдий тийм ч цахимжилт нь худалдааны салбарт эрс өөрчлөлтийг бий болгож цахим худалдааны салбар асар хурдацтай хөгжиж байна.

Үүнтэй холбогдуулан хил дамнасан болон дотоодын цахим худалдааны хүргэлтийн хэрэгцээ ч мөн нэмэгдэж байгаа тул дэлхийн бусад улс орны шуудангийн байгууллагууд хүргэлт, логистикийн чиглэл рүү түлхүү анхаарч байна.

Үүнээс гадна олон улсын шуудангийн салбар зардлыг бага байлгаж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс шуудангийн салбарын цахим шилжилтийг хурдасгахаар зорьж байна. Энэ нь хүргэлтийн тарифыг багасгах, маршрутыг оновчтой болгох, мөн хүргэлтийн хугацааг богино болгох ач холбогдолтой.

Цахим засаглалыг хөгжүүлэх чиглэлээр:

Монгол Улсын Их хурлаас цахим хөгжлийг эрчимжүүлэх багц хууль (*Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль*)-ийг 2021 онд батлан гаргаж, улмаар 2022 онд Монгол Улсын Засгийн газрын бүтцэд харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг, түүний харьяанд Үндэсний Дата Төв УТҮГ-г нэгтгэн, шинээр төрийн цахим үйлчилгээний нэр төрөл, чанар, стандарт, хүртээмжийг сайжруулах, төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан төрийн үйлчилгээ хүргэх үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангах чиг үүрэгтэй Засгийн газрын тохируулагч агентлаг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, төрийн цахим үйлчилгээний нэр төрөл, чанар, стандарт, хүртээмжийг сайжруулах, төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан төрийн үйлчилгээ хүргэх үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангах чиг үүрэгтэй И-Монгол академи УТҮГ-ыг тус тус байгуулсан. Мөн иргэн, хуулийн этгээд, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй хувийн хэвшлийн байгууллагын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд чиглэсэн кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, кибер халдлага, зөрчилд өртсөн дэд бүтэц, мэдээллийн системийг нөхөн сэргээхэд мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ыг бий болгосноор төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоог сайжруулах, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, салбар хоорондын уялдааг хангаж төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, иргэний мэдээлэл хайх, хүлээн авах, мэдэх эрхийг тэгш, хүртээмжтэй хангах, хүний хувийн мэдээллийг хамгаалах, цахим халдлага зөрчлөөс урьдчилсан сэргийлэх зэрэг арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Гэсэн хэдий ч Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч байгууллагаас үзүүлдэг үйлчилгээнд дахин инженерчлэл хийх, тэдгээрийн ашигладаг мэдээллийн системүүдийн уялдааг сайжруулах, салбар бүрд нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийг бий болгож, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах, дотоодын программ хангамж үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг баталгаажуулах, экспортод чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх, цахим засаглалыг хөгжүүлэхтэй холбогдсон олон улсын сайн туршлагыг нутагшуулж, шударга, ил тод, нээлттэй засаглалыг бэхжүүлэн төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээг хиймэл оюун ухаанд суурилсан дараа үеийн технологид тулгуурлан хөгжүүлж, зөөлөн болон хатуу дэд бүтцийн тасралтгүй хөгжүүлэх замаар газар зүйн байршлаас хамаарсан үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Өнөөгийн хүн төрөлхтний амьдрал мэдээлэл, харилцаа холбооны технологиос ихээхэн хамааралтай байна. Энэ нь хувь хүн, байгууллагууд хийгээд улс үндэстнийг

кибер халдлага (hacking), кибер терроризм, кибер гэмт хэрэг гэх мэт мэдээллийн системийн халдлагуудад өртөмтгий болгож байна.

Кибер орчинд мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээлэл солилцох тогтолцоог бий болгох, кибер орчинд хүний эрхийг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах, бүх нийтийн кибер аюулгүй байдлын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг чадавхжуулах, кибер аюулгүй байдлын өнөөгийн болон зорилтот түвшинг тогтоох, олон улсын стандарт, аргачлалыг нэвтрүүлэх, кибер аюулгүй байдлын уян хатан байдал, халдлагад хариу үйлдэл үзүүлэх чадамжийг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага тулгараад байна.

Кибер аюулгүй байдлын тухай хууль 2021 онд батлагдаж, 2022 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллага доторх мэдээллийн аюулгүй байдлын ойлголт муу, хууль, журамд тусгагдсан дотоод журмын хэрэгжилт болон эрсдэлийн удирдлага хангалтгүй байгаагаас гадна мэргэшсэн хүний нөөц дутмаг байгааг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Салбарын хүний нөөц, цахим ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр:

Монгол Улсын 21 аймаг, 330 суманд өндөр хурдны интернэтийн сүлжээ орсноор нийт өрхийн 80 гаруй хувь нь интернэт ашиглаж, үүрэн холбооны хэрэглэгчийн тоо жил жилээс жилд өсөн нэмэгдэж, 2023 оны байдлаар 4 сая орчим ухаалаг төхөөрөмж хэрэглэж байгаа статистик мэдээ гарсан. Өөрөөр хэлбэл Монгол Улсын иргэд гар утас, компьютер төдийгүй бүхий л электрон төхөөрөмжийг интернэтэд холбон хэрэглэж, ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох, мэдээлэл солилцох, харилцан холбогдох зэргээр өдөр тутмын амьдралдаа цахим технологийг өргөнөөр ашиглаж байна.

Хэдийгээр технологийн хөгжил нь олон асуудлыг шийдвэрлэж, шинэ боломжийг бий болгож байгаа хэдий ч шийдвэрлэх шаардлагатай зарим асуудлууд үүсэж байгаагийн дотор иргэдийн нас, технологийн талаарх мэдлэг ойлголт, цахим тоног төхөөрөмж ашиглах чадвараас хамаарч ялгаатай байна. Тухайлбал, бидний өдөр тутмын амьдралд тохиолддог санхүүгийн гүйлгээнүүдийг интернэт ашиглан зарим хүмүүс хурдан шуурхай хийж чаддаг байхад цахим ур чадварын талаар мэдлэг, ойлголт багатай иргэдийн хувьд энэ төрлийн боломж хязгаарлагдмал байна.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Үндэсний статистикийн хороотой хамтран 2022 онд хийсэн "Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээ"-ний түүвэр судалгаагаар иргэдийн цахим ур чадвар 43.8 хувьтай гарсан нь энэхүү ур чадварыг сайжруулахад ихээхэн анхаарах шаардлагатайг илтгэн харуулж байна.

Инновац, үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр:

Дэлхийн улс орнуудын инновацын чадамжийг үнэлдэг Глобал инновацын индексээр Монгол Улс инновацыг дэмжих институт, хүний нөөц болон судалгаа хөгжил, дэд бүтэц, бизнесийн орчин, мөн бүтээлч санаачилгын чиглэлээр сайжирч 2023 онд дэлхийн 132 орноос 68 дугаар байранд эрэмбэлэгдсэн боловч, мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээ, инновац шингэсэн бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай байгаа нь дээрх үнэлгээний тайлан мэдээнээс харагдаж байна.

Монгол Улсын хувьд дижитал эдийн засгийг дэмжих, мэдээллийн технологийн болон инновац шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр тодорхой ахиц дэвшил гарч байгаа ч Япон улсын Жайка байгууллага болон холбогдох бусад байгууллагаас

хамтран гаргасан “Монгол Улсын старт ап экосистемийн суурь судалгаа (2022 он)”-аар манай улс одоогоор хөгжлийн үе шатандаа байгаа боловч хөгжлийн чиглэлээр хөрөнгө оруулалтын сан бүрдүүлэх (61%), татварын бодлогыг сайжруулах (54%), инновац, оюуны өмчийн бодлогыг хамгаалах (39%), эдийн засгийн тогтвортой орчин бий болгох (59%), хүний нөөцийг бүрдүүлэх (63%) стратегийн бодлого төлөвлөлт, түүнийг хэрэгжүүлэх ажил дутмаг бөгөөд сайжруулах шаардлагатай байгааг дурдсан байдаг.

Иймд мэдээллийн технологи, инновац үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх хүрээнд гарааны бизнесийг тогтвортой хөгжүүлэх, инкубатор орчин бүрдүүлэх, технологийн шийдлийг дэмжих сэндрокс орчин, судалгаа шинжилгээ хийх орчныг бүрдүүлэх, сургалт, судалгааны байгууллагууд болон бизнесийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих зэрэг ажлуудыг цогц байдлаар хэрэгжүүлж, мэдээллийн технологийн шинэлэг шийдэл, инновац шингэсэн эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулах шаардлагатай байна.

Салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр:

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн тусламжтайгаар үндэсний хөгжлийг хурдасгахад салбар хоорондын уялдааг хангах нь чухал ач холбогдолтой бөгөөд төрийн захиргааны төв 18 байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд өгсөн өөрийн үнэлгээний дундаж 91.2%, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас өгсөн үнэлгээний дундаж 79.2% ба үүнээс харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн арга хэмжээг түүвэрлэн, хэрэгжилтэд өгсөн өөрийн үнэлгээний дундаж 89.9%-тай байна. 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр өөрийн үнэлгээнд 50 ба түүнээс доош хувьтай үнэлэгдсэн 54, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас өгсөн үнэлгээнд анхаарвал зохих тусгайлан заасан 13 тус тус харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр арга хэмжээ байгаа нь мэдээлэл хариуцагчийн цахим үйл ажиллагаа хариуцсан нэгж, албан тушаалтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зайлшгүй хэрэгцээ, шаардлагатай байна.

Мөн 2023 онд хийгдсэн “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний явц үр дүнгийн аудит (ГНАГ-2023/21-ШТА-ГА)-ын үр дүнд цахим хөгжил, харилцаа холбооны бодлого, төлөвлөлт, уялдааг хангасан салбар хоорондын нэгдсэн зохицуулалт, нэгдсэн байдалд онцгой анхаарах шаардлагатайг дурдсан байна.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандатыг тодорхойлохдоо чиг үүргийн шинжилгээ хийж, Монгол Улсын Үндсэн хууль болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 13 хууль, Олон Улсын гэрээ конвенц, төрийн алба, яамны эрхлэх асуудал, төсөв санхүүд хамаарах 26 буюу нийт 39 хуулийн хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон салбар, харьяа байгууллагуудад хуулиар олгосон чиг үүргийг хамруулан мандатын шинжилгээг хийж, дор дурдсан хүснэгтээр тодорхойлов.

Хүснэгт 1. Мандатын шинжилгээний хүснэгт

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		39
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	13
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	26

Ерөнхий чиг үүрэг 1: Харилцаа холбоо, инновац, гарааны бизнес, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, мэдээллийн технологи, шуудан, өргөн нэвтрүүлэг, радио давтамж, сансрын технологи, кибер аюулгүй байдлыг хангах хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, урт болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө боловсруулах, шаардагдах судалгаа шинжилгээ хийх, хөгжлийн бодлогын уялдааг хангах, бодлогын удирдамжаар хангах, хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх

Үндсэн чиг үүрэг (ҮЧҮ)	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ - 1.1: Сайдын эрхлэх асуудлын хүрээний тэргүүлэх чиглэл, нэгдсэн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийг боловсруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг бодлогын нэгдсэн арга зүйгээр дэмжиж, салбар дундын уялдааг хангахад чиглэх ба харилцаа холбоо, инновац, гарааны бизнес, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, мэдээллийн технологи, шуудан, цахим худалдаа, өргөн нэвтрүүлэг, радио давтамж, сансрын технологи, цахим засаглал, нийтийн мэдээллийн дэд бүтэц, нээлттэй өгөгдөл, кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр бодлого төлөвлөлт, зохицуулалттай холбогдсон шийдвэр гаргахад сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн даргад мэргэшлийн өндөр түвшний цаг үеэ олсон, шуурхай мэдээлэл, мэргэжлийн зөвлөгөө өгөх	1.Харилцаа холбоо, мэдээллийн технологи, шуудан, өргөн нэвтрүүлэг, радио давтамж, сансрын технологи, инновац, цахим засаглалын бодлого, стратегийг төлөвлөх, салбарын хөгжлийн бодлого, стандарт, төсөл, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх; 2.Алслагдсан сум, суурин газарт харилцаа холбооны үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх болон бүх нийтийн үйлчилгээний үүргийн талаарх бодлогыг тодорхойлох; 3.Төрөөс өргөн нэвтрүүлгийн хөгжлийг дэмжих, радио, телевизийн үндэсний бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг тодорхойлох; 4.Кибер аюулгүй байдал, нийтийн түлхүүрийн дэд бүтэц, хүний хувийн мэдээллийг хамгаалах талаарх бодлогыг тодорхойлох.	ҮАБЗ ЗГХЭГ Яамд Салбарын болон харьяа байгууллагууд ОУБ ТББ Хувийн хэвшил
ҮЧҮ - 1.2: Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, сайдын болон дээд газраас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих, салбарын хуулийн төсөл боловсруулах, хуулийн	1.Харилцаа холбоо, мэдээллийн технологи, шуудан, өргөн нэвтрүүлэг, радио давтамж, сансрын технологи, инновац, цахим засаглалын бодлого, стратегийг төлөвлөж, салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх.	ҮАБЗ ЗГХЭГ Яамд Авлигатай тэмцэх газар

давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах		Салбарын болон харьяа байгууллагууд
ҮЧҮ - 1.3: Салбарын олон талт болон хоёр талт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлогыг төлөвлөн, хэрэгжилтийг хангах, бүх талын харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэх, түншлэлийн түвшинд хүргэх, харилцааны үр ашгийг нь дээшлүүлэх, гишүүнчлэл бүхий байгууллагуудаас ирж байгаа хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, салбарын хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд оролцох, удирдлага зохицуулалтаар хангах	1.Олон улсын, бүсийн, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэх.	ЗГХЭГ Яамд Салбарын болон харьяа байгууллагууд
ҮЧҮ - 1.4: Салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн судалгаа, шинжилгээ хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, салбарын статистик мэдээллийг хөгжүүлэх бодлого, төсөл, хөтөлбөр боловсруулах, салбарын ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох, үр өгөөжийг нэмэгдүүлж судалгаа, шинжилгээг хөгжүүлэх цогц шийдэл гаргах, статистик мэдээ гаргаж, мэдээллийн сан байгуулах	1.Харилцаа холбоо, мэдээлэл технологийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг эрчимжүүлж, судалгаа хөгжлийн нэгдсэн тогтолцоог бий болгох ажлыг зохион байгуулах, зохицуулах; 2.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хүний нөөцийн бодлого боловсруулах, төлөвлөлт хийх.	Салбарын болон харьяа байгууллагууд
Ерөнхий чиг үүрэг 2:Нийтийн мэдээллийн дэд бүтцийг төрөөс иргэдэд үзүүлдэг үйлчилгээг дахин инженерчлэл хийх, төрийн үйлчилгээг түргэн, шуурхай, чирэгдэлгүй хүргэхэд чиглүүлэн хөгжүүлэх		
ҮЧҮ -2.1: Нийгэм, эдийн засгийн хөгжлийг мэдээллийн технологиор дэмжих, төрийн байгууллагуудын мэдээллийн системийн	1.Цахим засаглалыг хөгжүүлэх, нэвтрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;	ҮАБЗ ЗГХЭГ

уялдаа, холбоог төлөвлөж, зохион байгуулах, цахим засаглалын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд мэдээллийн технологи, программ хангамжийн хөгжил, инновацын бодлогыг түшиглэн төрийн үйлчилгээг нэгдсэн бодлого төлөвлөлттэйгөөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, тоон хуваагдлыг бууруулах, салбарын болон салбар дундын бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээж, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн бүртгэл хөтлөх	2.Төрийн цахим үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, нэгдсэн төлөвлөлт хийх, мэргэжил, арга зүй, технологийн шийдэл, удирдлагаар хангах; 3.Төрийн байгууллагуудын мэдээллийн сан, мэдээллийн систем, нээлттэй өгөгдлийг уялдуулах, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн тогтолцоо, нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх, зохион байгуулах, зохицуулах; 4.Цахим орчинд харилцаа холбоо, мэдээллийн технологийн зөв зохистой хэрэглээний соёлыг нэвтрүүлэх, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг бууруулах, иргэдийн мэдээлэл авах хүртээмжийг нэмэгдүүлэх.	Яамд, салбарын болон харьяа байгууллагууд ОУБ ТББ Хувийн хэвшил
ҮЧҮ - 2.2: Төрийн цахим үйл ажиллагаа болон үйлчилгээний талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн байгууллагуудын мэдээллийн сан, мэдээллийн систем, мэдээллийн технологийн төсөл, хөтөлбөрийн нэгдсэн бүртгэл хөтлөх, төрийн байгууллага, мэдээлэл хариуцагчаас төрийн үйлчилгээний нэгдсэн систем ашиглах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах, төрийн цахим үйлчилгээний нэгдмэл, тасралтгүй ажиллагааны бэлэн байдлыг хангах, төрийн үйлчилгээний дахин загварчлалын нэгдсэн төлөвлөлтийг хэрэгжүүлэх, мэдээлэл хариуцагч, иргэн, хуулийн этгээд тэгш ашиглах боломжийг хангах	1.Төрийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, бизнес процессын дахин инженерчлэл хийх.	ЗГХЭГ Яамд Салбарын болон харьяа байгууллагууд ОУБ ТББ Хувийн хэвшил

Ерөнхий чиг үүрэг 3: Гарааны бизнесийн эко системийг дэмжих, инновац шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг экспортод гаргах замаар цахим эдийн засгийг хөгжүүлэх чиглэлээр урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, түүнд нийцсэн төсвийн хэрэгцээний шинжилгээ хийх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах		
ҮЧҮ - 3.1: Хиймэл оюун ухаан, их өгөгдөл зэрэг дэвшилтэт технологид тулгуурлан нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгах, үндэсний инновацыг хөгжүүлэх бодлого боловсруулах, гарааны бизнесийн экосистемийг бий болгох, хөгжүүлэх, олон улсад өрсөлдөх чадамжийг дээшлүүлэн олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадны хөрөнгө оруулалт татах, мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх	1.Урт, дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан өндөр технологи, үндэсний инновацын тогтолцооны бодлого боловсруулах, хөгжлийн түвшнийг үнэлэх, инновацыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд зөвлөгөө, бүр талын дэмжлэг үзүүлэх; 2.Нийгэм, эдийн засгийн хөгжлийг инновац, мэдээллийн технологид тулгуурлан хурдасгах, өндөр технологи, үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагааг уялдуулах, судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах, зохицуулах.	ЗГХЭГ Яамд Салбарын болон харьяа байгууллагууд ОУБ ТББ Хувийн хэвшил
ҮЧҮ-3.2:Хиймэл оюун ухаан, их өгөгдлийн чиглэлээр баримтлах бодлогын чиглэл боловсруулах, стратеги, дүрэм, журам боловсруулах, хэрэгжилтийг хангах, хиймэл оюун ухаанд суурилсан үйлчилгээг нийгэм, эдийн засгийн бусад салбарт нэвтрүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог хангах, хиймэл оюун ухааны зүй зохистой хэрэглээг олон нийтэд сурталчлан таниулах	1.Их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилсан дэвшилтэт технологи хөгжүүлэх төлөвлөлтийг хийх, эрх зүйн баримт бичиг боловсруулах, түүнд нийцсэн төсвийн хэрэгцээний шинжилгээ хийх.	
ҮЧҮ- 3.3: Инновац, гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэдээллийн технологи, программ хангамжийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэсэн	1.Гарааны бизнесийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, олон улсад өрсөлдөх чадамжийг дээшлүүлэн, хөрөнгө оруулалт татах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс эдийн засагт үзүүлэх үр өгөөж нэмэгдүүлэх.	

бодлого боловсруулах, энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийж, гадаад, дотоодын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх		
Ерөнхий чиг үүрэг 4: Харилцаа холбоо, радио давтамж, хиймэл дагуул, шуудан, өргөн нэвтрүүлэг, сансрын технологийн орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нутагшуулах, төсөл хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах		
ҮЧҮ - 4.1: Харилцаа холбоо, шуудан, өргөн нэвтрүүлэг, сансрын холбооны хөгжлийн бодлого, стандарт, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, радио давтамжийн төлөвлөлтөд хяналт тавих, бүх нийтийн үйлчилгээний үүргийн бодлогыг хэрэгжүүлэх, олон улсын транзит урсгалыг дамжуулах сүлжээний газар зүйн шинэ чиглэлийг тодорхойлох, харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг өргөтгөх, нөөц сүлжээ байгуулах, радио өргөн нэвтрүүлгийн системийг хөгжүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах	1. Харилцаа холбоо, радио, өргөн нэвтрүүлгийн хөгжлийн бодлого, стандартыг хэрэгжүүлэх, харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг өргөтгөх, тоон радиогийн сүлжээ, нөөц сүлжээ байгуулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт тавих; 2. Монгол Улсын нутаг дэвсгэрээр олон улсын транзит урсгалыг дамжуулах сүлжээний газар зүйн шинэ чиглэлийг тодорхойлох, харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг өргөтгөх, нөөц сүлжээ байгуулах ажлыг зохион байгуулах, мэдээлэл, холбооны бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэхэд арга зүйн удирдамжаар хангах.	ЗГХЭГ Яамд Салбарын болон харьяа байгууллагууд ОУБ ТББ Хувийн хэвшил
ҮЧҮ - 4.2: Үндэсний радио давтамжийн төлөвлөлтийн газрын сүлжээний радио давтамжийн төлөвлөлтийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, үндэсний радио давтамжийн төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах, үндэсний радио давтамжийн төлөвлөлтийн сансрын сүлжээний радио давтамжийн төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах, хил залгаа улстай радио долгионы асуудлыг зохицуулах, сансрын технологи, сансрын холбооны хиймэл дагуулын үйлчилгээг нэвтрүүлж,	1. Үндэсний радио давтамжийн төлөвлөлт, хуваарилалтыг боловсруулах, үндэсний радио давтамжийн төлөвлөлтийн газрын сүлжээний радио давтамжийн нөөцийг хуваарилах ажлын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах; 2. Үндэсний радио давтамжийн төлөвлөлтийн сансрын сүлжээний радио давтамжийн нөөцийг хуваарилах ажлын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах; 3. Сансрын технологи, сансрын холбооны хиймэл дагуулын үйлчилгээг нэвтрүүлж, газар, сансар хосолсон өргөн зурвасын сүлжээг бий болгох, үндэсний хэмжээнд ашиглах, хэрэглээг	ЗГХЭГ Яамд Салбарын болон харьяа байгууллагууд ОУБ ТББ Хувийн хэвшил

газар, сансар хосолсон өргөн зурвасын сүлжээг бий болгох, үндэсний хэмжээнд ашиглах, хэрэглээг нэвтрүүлэх, тандан судалгааны хиймэл дагуулын мэдээг үндэсний хэмжээнд ашиглах, хэрэглээг нэвтрүүлэх	нэвтрүүлэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх; 4.Тандан судалгааны хиймэл дагуулын мэдээг үндэсний хэмжээнд ашиглах, хэрэглээг нэвтрүүлэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх.	
ҮЧҮ - 4.3: Харилцаа холбооны сүлжээг өргөтгөх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, шуудангийн маркийн бодлогыг хэрэгжүүлэх, шуудангийн нэгдсэн кодыг хаягжилтын тогтолцоотой уялдуулан зохицуулах, хэрэглээнд нэвтрүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, радио өргөн нэвтрүүлгийн системийг үе шаттайгаар тоон технологид шилжүүлэх, шуудан, өргөн нэвтрүүлгийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг эрхлэх	1.Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг зохион байгуулах; 2.Шуудан, цахим худалдааны чиглэлээр шинэ техник, технологийг нэвтрүүлэх, шуудангийн үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх, үнэ бүхий шуудангийн тэмдэгтийн талаар төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.	ЗГХЭГ Яамд Салбарын болон харьяа байгууллагууд ОУБ ТББ Хувийн хэвшил
Ерөнхий чиг үүрэг 5:Кибер аюулгүй байдлыг хангах асуудлыг нэгдсэн бодлого төлөвлөлтөөр хангах, хэрэгжилтийг зохион байгуулах		
ҮЧҮ - 5.1: Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, кибер аюулгүй байдлыг хангах бодлого, хууль тогтоомж, стратегийн хэрэгжилтийг зохион байгуулах, кибер аюулгүй байдлын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, цахим орчны зохистой хэрэглээг төлөвшүүлэх, кибер халдлага, зөрчлөөс	1.Кибер аюулгүй байдал, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн талаарх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, стратеги, дүрэм, журам боловсруулах, хэрэгжилтийг хангах; 2.Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх нийтийн төвийн чадавхыг бэхжүүлэх, кибер халдлага, зөрчлийн талаарх мэдээлэл солилцооны тогтолцоог бий болгох; 3.Кибер аюулгүй байдлын чиглэлээр дотоод, гадаадын болон олон улсын байгууллагатай хамтарч ажиллах;	ҮАБЗ КАБЗ ЗГХЭГ Яамд, салбарын болон харьяа байгууллагууд КХЗТТөвүүд

урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэдээлэл солилцооны тогтолцоог бий болгох, мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийхтэй холбогдох журмын хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээллийн аюулгүй байдлын шаардлага, стандартчиллыг хөгжүүлэх	4.Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх зөвшөөрөл олгох, хэрэгжилтэд хяналт тавих; 5.Кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөц бэлтгэх, олон нийтэд мэдлэг олгох, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах; 6.Хүний хувийн мэдээлэл, хүний эмзэг мэдээлэл, биометрик болон генетик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлыг хангах нөхцөл шаардлагыг тодорхойлох, хэрэгжилтийг хангуулах.	Их, дээд сургуулиуд ОУБ ТББ Хувийн хэвшил
Ерөнхий чиг үүрэг 6:Хүний нөөцийн удирдлагын шилдэг арга барилыг хэрэглэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар яамны аппаратыг цомхон, чадварлаг болгон өөрчлөн хөгжүүлэх		
ҮЧҮ- 6.1: Цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн албаны хүчээр яамны тасралтгүй, хэвийн, жигд ажиллагааг хангах	1.Төрийн захиргаа, хүний нөөцийн манлайллыг хангах, Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангах, яамны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, хяналт тавьж тайлагнах; 2.Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих; 3.Яам, харьяа байгууллагын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх; 4.Яам, харьяа байгууллагын хүрээнд нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах; 5.Сайдын эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагуудын үйл	ЗГХЭГ Сангийн яам Эдийн засаг, хөгжлийн яам Төрийн албаны зөвлөл Авлигатай тэмцэх газар Төрийн болон төрийн бус байгууллагууд Иргэд

	ажиллагааг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах;	
ҮЧҮ - 6.2: Хөгжлийн баримт бичгүүдэд тусгагдсан санхүү, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах үндсэн үүргийг хүлээж, байгууллагын стратеги, төлөвлөгөөнд нийцүүлэн санхүү, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл боловсруулах, төсвийг захиран зарцуулах, төсөл, арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх, санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх, гадаад хөрөнгө оруулалтыг дэмжих, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв боловсруулах, зарцуулах, төсвийн төслийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохицуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх, яамны санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах	1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал, хөрөнгө оруулалтын зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг төлөвлөх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах; 2.Сайдын эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагаанд Засгийн газраас төсөвлөсөн хөрөнгө, нөөцийг хуваарилан зохицуулах, харьяа төсөвт нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлагнал, төрийн өмчийн бүртгэлд, хяналт тавих, тайлагнах, яамны санхүү, аж ахуйн үйл ажиллагааг тасралтгүй явуулах.	
Ерөнхий чиг үүрэг 7: Хөгжлийн бодлогын баримт бичиг, салбарын стратегийн төлөвлөгөө, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангуулах, хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж өгөх		
ҮЧҮ - 7.1: Яамны болон салбарын байгууллагуудын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, хууль тогтоомж, гэрээ, хэлэлцээр, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, үр дүнг үнэлэх	1.Салбарын хууль тогтоомж, хөгжлийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтийг хангасан эсэхэд хяналт тавих, төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчид тайлагнах; 2.Салбарын хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар зөвлөмж гаргах, салбарын төвлөрсөн бус статистик мэдээллийг эрхлэн хөтлөх;	ЗГХЭГ Салбарын болон харьяа байгууллагууд

	3.Яам, сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт шалгалт, дотоод аудит явуулах, үр дүнд үнэлгээ хийх; 4.Салбарын хэмжээнд улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтийг хангасан эсэхэд хяналт тавих; 5.Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийсэн тайлангийн нээлттэй ил тод байдлыг хангах.	
Ерөнхий чиг үүрэг 8: Эрсдэлд суурилсан салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх замаар хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандартын хэрэгжилт, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ашиглалт, үйлчилгээний тасралтгүй, хэвийн найдвартай ажиллагааг хангуулах		
ҮЧҮ - 8.1: Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, тайлагнах, хэрэгжилтийг хангуулах, эрсдэлийн шинжилгээ хийх, эрсдэлийг бууруулах, үнэлэлт дүгнэлт өгч, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөтлөх, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм стандартын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр улсын хэмжээнд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт шалгалт	1.Салбарын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, тайлагнах, хэрэгжилтийг хангуулах, эрсдэлийн шинжилгээ хийх, эрсдэлийг бууруулах, үнэлэлт дүгнэлт өгч, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөтлөх; 2.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм стандартын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх; 3.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт шалгалт хийх, холбогдох арга хэмжээг авах; 4.Салбарын хяналт шалгалтын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, нэмэлт	Салбарын болон харьяа байгууллагууд Хувийн хэвшил

хийх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг удирдах, зохион байгуулах, улсын байцаагчийг шүүхэд төлөөлөх, харилцаа холбооны салбарын хяналтыг улсын хэмжээнд удирдаж, нэгдсэн бодлого, арга зүй, зохион байгуулалтаар хангах, сургаж мэргэшүүлэх	өөрчлөлт оруулах, шинэчлэх шаардлагатай хууль тогтоомжийг тодорхойлох, түүний мөрөөр зохих арга хэмжээ авах давхардал хийдлийг арилгах, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг удирдах, зохион байгуулах, улсын байцаагчийг шүүхэд төлөөлөх; 5.Харилцаа холбооны салбарын хяналтыг улсын хэмжээнд удирдаж, нэгдсэн бодлого, арга зүй, зохион байгуулалтаар хангах, сургаж мэргэшүүлэх.	
--	---	--

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн хөгжил, дэвшил нь Монгол Улсын хөгжлийн хурдасгуур байна.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлж, мэдлэг оюунд тулгуурласан цахим үндэстнийг цогцлоон хөгжүүлнэ.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх салбарын хэмжээнд тулгамдаж байгаа асуудлыг төлөвлөлтийн баримт бичигт үе шаттайгаар тусган хэрэгжүүлэх зорилгоор салбарын өнөөгийн нөхцөл, байдалд тулгуурлан дотоод болон гадаад орчны шинжилгээг хийв. Түүнчлэн гадаад болон дотоод орчны зүгээс нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодорхойлов.

5.1. Дотоод орчны шинжилгээ

Орчны хүчин зүйл	Үзүүлэх нөлөөлөл
Байгууллагын тогтолцоо	1.Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, Засгийн газрын 2024 оны 44 дүгээр тогтоолоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталсан. Уг тогтоолоор хиймэл оюун ухаан, их өгөгдөл бүхий дэвшилтэт технологид тулгуурлан нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгах, үндэсний инновац, гарааны бизнесийн экосистемийг бий болгох, хөгжүүлэх чиг үүрэг бүхий Инновацийн бодлого, зохицуулалтын нэгж яамны бүтцэд шинээр нэмэгдсэн. Стратеги, бодлого, төлөвлөлтийн газар (Гадаад, харилцаа, хамтын ажиллагааны нэгж, Салбарын эрх зүйн орчны шинэчлэл, хуулийн нэгж, Салбарын хүний нөөц, судалгааны нэгжтэй), Инновацийн бодлого, зохицуулалтын газар (Их өгөгдөл, хиймэл оюун ухааны нэгж, Гарааны бизнесийн эко системийн нэгжтэй), Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газар (Төрийн үйлчилгээний дахин загварчлалын нэгжтэй), Харилцаа холбооны бодлого зохицуулалтын газар (Сүлжээний дэд бүтцийн нэгж, Сансрын технологийн хэрэгжилтийн нэгжтэй), Кибер аюулгүй байдлын бодлого зохицуулалтын газар, Төрийн захиргааны удирдлагын газар (Хөрөнгө оруулалт, санхүүгийн нэгжтэй), Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Салбарын хяналтын газар бүхий нийт 8 газар, 9 хэлтэстэй болж өргөжсөн. 2.Тус яамны харьяанд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, И-Монгол академи УТҮГ, Үндэсний дата төв УТҮГ, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ, Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ зэрэг байгууллагууд ажиллаж, үндэсний цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, боловсруулалтын үйл ажиллагаа, мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд чиглэсэн кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, кибер

	халдлага, зөрчилд өртсөн дэд бүтэц, мэдээллийн системийг нөхөн сэргээхэд мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх, төрийн цахим шилжилтийг дэмжих, төрийн үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах ажлуудыг гүйцэтгэж байна. 3.Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс татан буулгаж, чиг үүргийг салбарын яамдад шилжүүлсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 469 дүгээр тогтоолын 1 дэх заалтаар Цахим хөгжил, харилцаа холбооны яамны бүтцэд Салбарын хяналтын газрыг байгуулж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, тайлагнах, хэрэгжилтийг хангуулах, эрсдэлийн шинжилгээ хийх, эрсдэлийг бууруулах, хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөтлөх, хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм стандартын хэрэгжилт, харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр улсын хэмжээнд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах, салбарын хяналтыг улсын хэмжээнд удирдаж, нэгдсэн бодлого, арга зүй, зохион байгуулалтаар хангах, зөвлөн туслах чиг үүргийг хэрэгжүүлж байна. 4. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан 2001 онд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг байгуулж, тус сангийн үйл ажиллагааг Харилцаа холбооны тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 354 дүгээр тогтоолоор “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журам”-ын хүрээнд зохицуулж байна. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн гол зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдарч байгаа хүн амын харилцаа холбооны үйлчилгээний тоон хуваагдлыг багасгах, хүртээмжийг нэмэгдүүлэх, зах зээлийн ялгавартай байдал (market gap/true access gap)-ыг арилгах, улмаар улс орны эдийн засагт хувь нэмэр оруулахад оршдог. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 447 (+100) цэгт хөдөлгөөнт холбооны сүлжээ нэвтрүүлэх, өргөтгөх, шинэчлэх, 321 цэгт интернэтийн үйлчилгээ нэвтрүүлэх, сайжруулах, 62 цэгт харилцаа холбооны нэг цэгийн барилга, холбооны цамхаг, шилэн кабелийн сүлжээ байгуулах, 330 суманд шуудангийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах төслүүдийг хэрэгжүүлээд байна. 5.Өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх сан Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан нь алслагдсан, сүлжээ хүрээгүй газарт өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг, бүтээл, үйлдвэрлэл хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх зорилготой. Засгийн газраас Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн дүрэм, сан бүрдүүлэх, сангийн хөрөнгийг
--	---

	зарцуулах журмыг 2023 оны 364 дүгээр тогтоолоор баталсан. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг хөгжүүлэх, үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн. Монгол Улсын хэмжээнд нийт 260 өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсоноос Монголын Үндэсний олон нийтийн телевизийн 5, олон нийтийн радиогийн 4, Улаанбаатар хотод өргөн нэвтрүүлгийн телевизийн 18, арилжааны телевизийн 54, төлбөртэй телевизийн 20, радиогийн 35, орон нутагт телевизийн 50, радиогийн 23, мөн радио, телевизийн газрын сүлжээний 2, олон суваг дамжуулах 35 үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээд тус тус байна. Монгол Улсын нийт өрхийн 97.3 хувь нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг радио, телевизийн газрын сүлжээ болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжуулан хүлээн авч үзэж байна. Түүнчлэн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр гадаадын 199 сувгийг дахин дамжуулж хэрэглэгчид хүргэж байна.
Хүний нөөц	Салбарын хэмжээнд 2790 байгууллага үйл ажиллагаа эрхэлж, нийт 16389 ажилтан, албан хаагчид ажиллаж байна. Эдгээр ажиллагчдын 59 хувь нь салбарын үндсэн ажилтан, албан хаагчид байна (1212.мн, 2023). Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад 12,232 хүн ажиллаж байгаагаас 61,77% нь Мэдээлэл холбоо, 25,75% нь өргөн нэвтрүүлэг, 12,48% нь шуудангийн сүлжээ, үйлчилгээний чиглэлээр ажиллаж байна (ХХЗХ, 2023). Улсын хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд 150 282 оюутан суралцаж байгаагаас харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр 6.26 5.38 % буюу 9420 оюутан суралцаж байгаа бөгөөд бакалаврт 94.5 хувь, магистрт 4.7 хувь, докторт 0.4 хувь нь суралцаж байна. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн талаар 2021 онд хийсэн судалгааны тайланд манай улс 2025 он гэхэд 3500 орчим мэдээллийн технологийн чиглэлийн мэргэжилтэй ажиллах хүчний дутагдалд орох талаар дурдсан байдаг (ХХМТГ, 2021).
Санхүүгийн нөөц	2023 оны жилийн эцсийн байдлаар харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын үйл ажиллагааны орлого нь 2,098.1 тэрбум болж, өмнөх оны мөн үеэс 12.8 хувь, төсөвт төвлөрүүлсэн орлого 9.8 хувиар нэмэгдэж 356.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Мэдээлэл, технологийн салбар нь бусад салбар буюу уул уурхай, хөдөө аж ахуй зэрэг салбаруудаас илүү хурдацтай өөрчлөгдөж байна. Хэдийгээр энэ салбар нь хөрөнгө оруулалт, түүхий эд, дэд бүтэц бага шаардах боловч ур чадвартай хүний нөөц, тогтвортой ажиллах хүч, санхүүгийн дэмжлэг шаардлагатай салбар юм.

5.2.Гадаад орчны шинжилгээ

Орчны хүчин зүйл	Үзүүлэх нөлөөлөл
------------------	------------------

УИХ, Засгийн газрын түвшинд	1.Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг Засгийн газрын 2022 оны 13 дугаар тогтоолоор баталж, Засгийн газар болон Улсын Их Хурлын түвшинд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарыг төлөөлөх төлөөлөлтэй болсон. 2.Монгол Улсын Засгийн газраас харилцаа холбооны салбарын хөгжлийг хурдасгах, шинэ техник, технологи нэвтрүүлэх, харилцаа холбооны хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд харилцаа холбооны зах зээл дэх төрийн оролцоог багасгаж, салбарын үйл ажиллагааг бүрэн либералчилж, хувийн хэвшлийн байгууллагуудыг дэмжиж ажилласны үр дүнд сүүлийн 20 жилийн хугацаанд үүрэн холбооны 3G болон 4G/LTE сүлжээг амжилттай нэвтрүүлж, хэрэгжүүлсэн. 2023 оны жилийн эцсийн байдлаар үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо 4,8 саяд хүрч, Монгол Улсын нийт хүн амын 90 гаруй хувь нь хөдөлгөөнт өргөн зурвасын сүлжээнд хамрагдан, орон зай, цаг хугацаанаас үл хамаарч төрөл бүрийн үйлчилгээг цахим хэлбэрээр авч байна. 3.Монгол Улсад инновацыг дэмжих, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих экосистемийг бүрдүүлэх, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, блокчэйнд суурилсан платформууд, программ хангамжийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, тус салбарын хүний нөөцийг чадавхжуулах, хөрөнгө оруулалтыг татаж, мэдээллийн технологийн салбарын эдийн засгийн салбарт эзлэх хувийг нэмэгдүүлэх чиглэлд УИХ-ын Инновац, цахим бодлогын байнгын хороо ажиллаж байна.
Хууль, эрх зүйн зохицуулалтын хувьд	1.Хууль эрх зүйн орчны нөлөөлөл нь батлагдан гарсан хууль эрх зүйн баримт бичгүүдэд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын эрх ашгийг хэрхэн тусгаснаас шууд хамаарна. 2.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үйл ажиллагаанд хамаарах 13 хуулийг тус салбарын үйл ажиллагаанд дагаж, мөрдөж байна. 3.Цахимын хөгжлийн багц хуулиуд болох Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай хуулиуд нь 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. 4.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийт 430 орчим хуулийг судалж үзэхэд зөвхөн “бичгээр” буюу “цаасан хэлбэрээр” гэж хэлбэр заасан үг хэллэгтэй 169 хуулийн 869 заалт, хэсэг байгааг тогтоож, тэдгээрээс 109 хуульд нэмэлт өөрчлөлт оруулан 2023 оны 12 сарын 18-ны өдөр Улсын Их Хурлаар батлуулсан.

